

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД


Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэлд:

“IX.ХЭЛЭЛЦСЭН нь: “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжиж, хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган тогтоол гаргахаар тогтов.

2. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал”-ын үйл ажиллагааг 2018 онд багтаан эхлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах, “Чингис хаан” олон улсын нисэх буудал”-ыг шинэ нисэх буудал руу шилжүүлсэн тохиолдолд Буянт-Ухаа дахь одоогийн барилга байгууламжийн өмчлөл, эзэмшил, ашиглалттай холбоотой асуудлыг шийдвэрлэх талаар санал боловсруулан Засгийн газарт оруулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэд даалгав.

3. “Төв аймгийн Хөшигийн хөндийд баригдах нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-нд тодотгол хийх, шинэ хот байгуулах, түүнийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж Засгийн газарт оруулах талаар Засгийн газрын 2017 оны 105 дугаар тогтоолоор өгсөн үүргийг хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Нийслэлийн Засаг дарга С.Батболд, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал нарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР